



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 01 сарын 12 өдөр

Дугаар 1107

Шивээговь сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны өрөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаал “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд сүм орон нутгийн бүрэн танилцуулга, дэлгэрэнгүй мэдээлэл, байгаль орчны онцлогийг харуулсан видео контент бэлтгэх ажлыг хийж, иргэдэд сурталчлан таниулах, олон нийтийн мэдээлэл сошиалаар нэвтрүүлэх ажилд 3,300,000 (гурван сая гурван зуун мянга) төгрөгийг зарцуулсугай.

2. Видео контент бэлтгэх ажлыг хийж, иргэдэд сурталчлан таниулах олон нийтийн мэдээлэл сошиалаар нэвтрүүлэх үйл ажиллагаанд зарцуулагдах 3,300,000 (гурван сая гурван зуун мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зохих журмын дагуу гаргахыг Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ц.Цэрэндорж), нягтлан бодогч (Д.Сэлэнгээ) нарт зөвшөөрсүгэй.

3. Видео контент бэлтгэх ажлыг чанартай гүйцэтгүүлж, үйл ажиллагааны үр дүнг тайлагнан ажиллахыг Мэдээ мэдээлэл, олон нийттэй харилцах ажилтан (Н.Амаржаргал)-д үүрэг болгосугай.

4. Тус ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, журмын дагуу гүйцэтгүүлж авахыг Засаг даргын орлогч (Ч.Сугармаа), Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн (М.Гантуяа), Мэдээ мэдээлэл, олон нийттэй харилцах ажилтан (Н.Амаржаргал) нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА *П.ГАНЧИМЭГ*

